



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 254

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус  
гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн 05/7212 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийг харгалзан "Дарханы төмөрлөгийн үйлдвэр" төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүнээр Жамъяангийн Ганбаатар, Цэрэнгийн Сүхбаатар, Цогтбаярын Ариунболд нарыг 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс томилсугай.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ